



МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: (976-51) 26-35-06,
Цахим шуудан: info@mimr.gov.mn
цахим хуудас: www.mimr.gov.mn

2025. 11. 06 № 01/3187


танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу хийсэн Дотоод аудитын тайланг үүгээр хүргүүлж байна.

Тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, арга хэмжээний биелэлтийг 2026 оны 02 дугаар улиралд багтааж ирүүлнэ үү.

Хавсралт 24 хуудастай.



Г.ДАМДИННЯМ

1508 08 1010



**АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ**

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Үндэсний геологийн албаны геологийн судалгааны “Аргачлал хяналтын зардал данс”-ны зарцуулалтад хийсэн хяналт шалгалт

Хамрах хугацаа: 2023-2024 он

2025 он

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аудит хийсэн байгууллага: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Аудит хийгдсэн байгууллага: Үндэсний геологийн алба

Аудитын төрөл: Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт

Аудит хийх хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн дарга: ХШҮДАГ-ын дарга	Б.Өнөмөнх
Гишүүд: ХШҮДАГ-ын ахлах шинжээч ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн	И.Баттуяа Б.Баттуул
Нарийн бичгийн дарга: ХШҮДАГ-ын мэргэжилтэн	Г.Батчимэг

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

- 2.1 Аудитын зорилго
- 2.2 Аудитын цар хүрээ
- 2.3 Аудитын арга, аргачлал

3. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

- 3.1 Засаглалын удирдлагын талаар
- 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
- 3.3 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

- 4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл
- 4.2 Өмнө хийгдсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт
- 4.3 Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

1. ТАНИЛЦУУЛГА

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/106 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Ашигт малтмалын тухай хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-аар зохицуулагдах Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлын хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад оршино.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Дотоод аудитад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-аар зохицуулагдах Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардал дансны 2023, 2024 оны төлөвлөлт, гүйцэтгэлийг хамруулав.

2.3 Аудитын арга, аргачлал

Тус байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмыг танилцуулж, удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, ярилцлага хийх, тулган баталгаажуулах, нягтлан шалгах зэрэг аудитын арга зүйг ашиглав.

Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг аудитын нотолгоо цуглуулж дүгнэлт гаргасан болно.

3. ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор бүтэц орон тооны хязгаарыг 35 байхаар батлагдаж 2020 оны 09 дүгээр сараас үйл ажиллагаа эрхэлж байна.

Хуулиар олгосон чиг үүргүүдийн хүрээнд:

1. Ашигт малтмалын тухай хууль:

- 11.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, судалгаа, шинжилгээ хийх;

- 11¹.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх;
 - 11¹.1.3. Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх;
 - 11¹.1.4. Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх.
2. Газрын хэвлийн тухай хуулийн 4.2, 6.3, 10.1, 12, 20.2, 22.1, 23, 41.2, 43.1, 43.2, 45, 46, 47, 48, 51, 52.1, 53.2, 54 /Газрын хэвлийн хуулийн холбогдох бусад заалтууд/

Дээрх үндсэн чиг үүрэг, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого зорилт, дээд байгууллагын гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд батлагдсан 35 орон тоо хүрэлцээгүй байна.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо сул байгаагаас дараах эрсдэлүүд үүсэж байгааг анхаарах. Үүнд:

Аргачлал хяналтын зардал дансны төлөвлөгөөнд бэлтгэл ажил хангагдаагүй хэрэгжихгүй төсөл арга хэмжээг тусгах, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, шаардлагагүй худалдан авалтыг хийх;

Мэргэжлийн хэлтсүүдийн хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн гүйцэтгэлд байнгын хяналт тавих, үр дүнгийн тайланг геологийн даалгаврын дагуу хугацаандаа чанартай хүлээн авахад эрсдэл үүсэх;

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй, эрсдэлийн бүртгэл байхгүй;

Түүнчлэн 2025 оноос төслийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт тавих чиг үүрэгтэй албан тушаалтан байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хавсран гүйцэтгэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж, байгууллагын болон төслүүдэд тавих санхүүгийн үйл ажиллагааны хяналт сулрах, цаашлаад тухайн ажлын байрууд нь бие биедээ хяналт тавих чиг үүргийг алдагдуулж ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байгааг анхаарах;

Цаашид байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээг төлөвлөх, тайлагнах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

3.3 Дотоод хяналтын талаар

Үндэсний геологийн алба нь дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэг мэргэжилтэнтэй бөгөөд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдох газруудад мэдээ тайлан хүргүүлэх чиг үүрэгтэй. Дотоод хяналт тавих чиг үүргийг байгууллагын дарга, нэгжийн удирдлагууд хэрэгжүүлэн ажиллаж байна. Дотоод хяналтын чиг үүргийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллах шаардлагатай.

1. АУДИТЫН ҮР ДҮН**1.2 АРГАЧЛАЛ ХЯНАЛТЫН ЗАРДАЛ ДАНСНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

Аргачлал хяналтын зардал дансанд 2023 оны эхээр 572,731.1 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба 2023 онд геологийн судалгааны 45 төслөөс 348,254.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Байгууллагын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “2023 оны аргачлал, хяналтын төлөвлөгөө, төсөв батлах тухай” А/08 дугаар тушаалаар 25 арга хэмжээнд зориулж 934,091.2 мянган төгрөг тусгаснаас нийт 325,253.8 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөний 34.8%-г зарцуулсан байгаа нь төлөвлөлтийг “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-нд заасны дагуу оновчтой төлөвлөх, хэрэгжүүлж болохуйц, бодитой төлөвлөх нь чухал байна.

АРГАЧЛАЛ ХЯНАЛТЫН ЗАРДАЛ ДАНСНЫ 2023 ОНЫ ЗАРЦУУЛАЛТ*/мян.төгрөг/*

Д/Д	Зардлын ангилал	Төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	201,148.0	132,826.2
2	МСК-ын үйл ажиллагааны зардал	МСК-ын үйл ажиллагааны зардал	86,800.0	82,877.3
3	РЗ-ын үйл ажиллагааны зардал	РЗ-ын үйл ажиллагааны зардал	31,980.0	24,392.3
4	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж авах	Геологийн судалгааны ажилд хяналт тавихад шаардлагатай багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж	12,970.0	-
5	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Эрүүл, аюулгүй ажиллагаа болон үйл ажиллагаа сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа	22,250.00	-
6	Геологийн судалгааны ажлыг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах	Үр дүнгийн тайланг онцсайн хамгаалсан гүйцэтгэгчид олгох зардал	15,000.00	-
7	Шинжээчийн зардал	Үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх	70,000.0	1,890.6
8	ЭБМЗ-ийн үйл ажиллагааны зардал	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн улсын төсвийн санхүүжилттэй судалгаа хэлэлцэх салбар зөвлөлийн зардал	58,000.0	-
9	Салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах	Геологийн салбарын хууль, тогтоомжийн төслийг боловсруулан танилцуулах, санал авах хэлэлцүүлэг зохион байгуулах	8,000.0	2,000.0

10	Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, цахим болон хээрийн сургалт зохион байгуулах	Геологичдын мэргэжил дээшлүүлэх практик сургалт-Шинэ дэвшилтэт программ хангамж ашиглалт, зураглал, эрлийн дадлагажих сургалт	32,000.0	19,016.9
11	Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, цахим болон хээрийн сургалт зохион байгуулах	Геологичдын ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулах зардал	76,188.0	-
12	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр дээж, сорьц авах, лабораторийн шинжилгээ хийлгэх зардал	3,000.0	-
13	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Тайлан мэдээ хүлээж авах үйл ажиллагаа болон хяналт шалгалтын цахимжилт	49,000.0	-
14	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах	Гео экологийн заавар зөвлөмж боловсруулах	45,000.0	-
15	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах	1:25000-ны масштабын геологийн зураглал хийх, түүнд тавигдах шаардлага боловсруулах зардал	45,000.0	-
16	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах	1:50000-ын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчлол зохиох	50,000.0	-
17	Салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн талаар олон нутагтай хамтран ажиллах зардал /маргаантай асуудлыг шийдвэрлэх гэх мэт/	3,000.0	-
18	Хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах	Монгол улсын геологийн салбарын улсын зөвлөгөөн зохион байгуулах зардал	30,000.0	26,940.7
19	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах	1:25000-ын масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага хэвлэх	2,000.0	-
20	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах, хэвлэн нийтлэх	1:50000-ын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчлол хэвлэх зардал	2,000.0	-
21	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж худалдан авах	Хяналтад шаардагдах архивын нэгж үүсгэхэд ашиглагдах тоног төхөөрөмж, шүүгээ тавиур, хангамж худалдан авах, засварлах зардал	29,000.0	-

22	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах, хэвлэн нийтлэх	Геологийн шинэлэг мэдээлэл бүхий товхимол бэлтгэх /улирал тутам/, хэвлэх зардал	1,000.0	-
23	Салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах	Геологи судалгааны төсөл хэрэгжүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн бусад зардал	15,855.3	-
24	Салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах	Зүүн өмнөд Азийн гео-шинжлэх ухааны төрийн байгууллагуудын холбооны 2023 оны гишүүнчлэлийн хураамж	35,180.0	35,310.0
25	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх	Магадалшгүй ажлын зардал	9,689.8	
			934,091.0	325,253.7

Түүнчлэн Монголын стратиграфийн комисс, Редакцийн зөвлөл нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний Геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулаагүй, төлөвлөгөөний дагуу хийсэн ажлаа хангалтгүй тайлагнасан байна.

Аргачлал хяналтын зардал дансанд 2024 онд 444,943.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Байгууллагын даргын 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөнд 47 арга хэмжээнд зориулж 1,149,052.6 мянган төгрөг тусгаснаас нийт 808,064.2 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Үүнд:

АРГАЧЛАЛ ХЯНАЛТЫН ЗАРДАЛ ДАНСНЫ 2024 ОНЫ ЗАРЦУУЛАЛТ

/мян.төгрөг/

Д/Д	Зардлын ангилал	Төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээж авах үйл ажиллагаа	103,781.90	85,966.76
2	МСК-ын үйл ажиллагааны зардал	Монголын стратиграфийн комиссын зардал	146,078.60	109,157.33
3	РЗ-ын үйл ажиллагааны зардал	Редакцын зөвлөлийн зардал	111,948.60	55,632.27
4	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж авах	Хээрийн шуурхай хяналтад шаардагдах багаж хэрэгсэл	17,500.00	17,500.00
5	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж авах	Хээрийн шуурхай хяналтад шаардагдах хувцас / хавар намар /	19,800.00	19,800.00
6	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж авах	Хээрийн шуурхай хяналтад шаардагдах хувцас / өвөл /	19,800.00	19,800.00
7	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж авах	Геологийн судалгааны тайланг архивлахад шаардагдах зардал	18,000.00	18,000.00
8	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Эрүүл мэндийн шинжилгээ	14,000.00	12,000.00

9	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Эм эмнэлгийн хэрэгсэл	14,681.90	14,000.00
10	Геологийн судалгааны ажлыг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах	Үр дүнгийн тайланг онцсайн хамгаалсан гүйцэтгэгчид олгох зардал	15,000.00	-
11	Шинжээчийн зардал	Үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх	180,293.46	52,800.00
12	ЭБМЗ-ийн үйл ажиллагааны зардал	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн улсын төсвийн санхүүжилттэй	72,704.18	56,829.44
13	Салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах	Геологийн салбарын хууль, тогтоомжийг олон улсад сурталчлах, олон улсын туршлага судлах зардал	40,000.00	60,047.74
14	Хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах	Монгол Улсад Үндэсний геологийн алба үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах зардал	30,000.00	87,385.60
15	Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, цахим болон хээрийн сургалт зохион байгуулах	Геологичдын ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах зардал	76,188.00	24,504.47
16	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр дээж, сорьц авах, лабораторийн шинжилгээ хийлгэх зардал	5,000.00	461.73
17	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Тайлан мэдээ хүлээн авах, хяналт шалгалтын цахимжилт	19,500.00	-
18	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах	Гео экологийн заавар, зөвлөмж боловсруулах	10,796.00	-
19	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах	1:25000-ны масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага боловсруулах зардал	19,800.00	-
20	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж худалдан авах	Шинжлэх ухаан, технологийн санд хадгалагдаж байгаа Байгалийн шинжлэх ухаан, технологийн судалгааны ажлын тайлангуудыг Геологийн баримтын төв архивд шилжүүлэх зардал	19,500.00	19,500.00
21	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж худалдан авах	ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн Эрдэс баялгийн музейн урсгал зардал	15,000.00	15,000.00
22	Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, цахим болон хээрийн сургалт зохион байгуулах	Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ болон Үйлдвэрлэлийн геологичдыг дэмжсэн сургалтын зардал	19,000.00	5,600.00
23	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах, хэвлэн нийтлэх	1:25000-ны масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага хэвлэх	2,000.00	-

24	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах, хэвлэн нийтлэх	1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчлол хэвлэх зардал	2,000.00	-
25	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах	Нэр томъёоны толь бичиг гаргах /сэдэв тус бүрд/	66,400.00	66,400.00
26	Салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах	Геологийн судалгааны төсөл хэрэгжүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн бусад зардал эрх зүйн маргаантай асуудлыг шийдвэрлэх орон нутагтай хамтран ажиллах	15,000.00	-
27	Арга аргачлал, норм дүрэм, заавар боловсруулах, хэвлэн нийтлэх	Геологийн шинэлэг мэдээлэл бүхий товхимол бэлтгэх /улирал тутам/, хэвлэх зардал	1,000.00	-
28	Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж худалдан авах	Хяналтад шаардагдах архивын нэгж үүсгэхэд ашиглагдах тоног төхөөрөмж, шүүгээ тавиур, хангамж худалдан авах, засварлах зардал	13,000.00	12,800.00
29	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах	Бичиг хэрэг	6,400.00	6,500.00
30	Салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах	Зүүн өмнөд Азийн гео-шинжлэх ухааны төрийн байгууллагуудын холбооны 2024 оны гишүүнчлэлийн хураамж	35,180.00	34,270.00
31	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх	Магадлашгүй ажлын зардал	19,700.00	14,108.86
		НИЙТ	1,149,052.65	808,064.19

Төлөвлөгөөнд нэр томъёоны толь бичиг гаргах ажлыг сэдэв тус бүрээр задлан оруулсан, бэлтгэл ажил хангагдаагүй ажлуудыг төлөвлөсөн, аргачлал хяналтын зардал данснаас зориулалт бусаар тухайлбал ШУТИС-ийн Эрдэс баялгийн музейн урсгал зардал 15.0 сая төгрөг, албан хаагчдад витаминжуулалт, вакцинд зориулж 14.0 сая төгрөг зарцуулжээ.

Түүнчлэн хээрийн шуурхай хяналтад шаардагдах багаж хэрэгсэлд үүргэвч, борооноос хамгаалах хаалт зэргийг ажиллаж байсан орон тооноос хэтрүүлэн авч 17.5 сая төгрөгийн шаардлагагүй худалдан авалтыг хийсэн, хээрийн шуурхай хяналтын хувцас авахад зориулан шууд худалдан авалт хийхээр босго үнэд тааруулан 39.6 сая төгрөгийг хоёр арга хэмжээ болгон хувааж төлөвлөсөн, зах зээлийн үнээс хэт өндөр үнэ бүхий хувцсыг байгууллагын нийт ажиллаж байсан орон тооноос хэтрүүлэн худалдан авчээ.

Аргачлал хяналтын зардлыг санхүүжүүлэх төлөвлөгөөнд “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын 3.2.18, 3.2.19 заалтыг үндэслэн төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах шаардлагатай.

1.3 ӨМНӨ ХИЙГДСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус байгууллагын 2023 оны дотоод аудитаар илэрсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийг харуулбал:

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт
1	Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулах. Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө ажлын даалгавар, зураг төсөвтэй бараа, ажил, үйлчилгээг тусгах.	Аргачлал хяналтын зардал данснаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг ТБОНӨХББАҮХАТХуулийн босго үнийг баримтлан байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн тусгаагүй байна. Хэрэгжилт 50%
2	Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн босго үнийг баримтлан цахим дэлгүүрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх.	Үндэсний геологийн албаны худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнөөс харахад Урсгал зардал, Мэдээлэл технологи, Багаж хэрэгсэл, "Хээрийн шуурхай хяналтад шаардагдах хувцас /хавар, намар, өвөл/ бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг 2, 3 дугаар улиралд эхлүүлэхээр төлөвлөсөн байна. Цаашид төлөвлөлтийг 1 дүгээр улиралд багтааж төлөвлөхөөр зохион байгуулах шаардлагатай. Хэрэгжилт 70%
3	Геологийн судалгааны төслүүдийн барьцаа хөрөнгө, гүйцэтгэлийн баталгаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахад хүрэлцэхгүй байгааг анхаарч, журамд өөрчлөлт оруулах.	"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох" журмын төсөлд санал тусгаагүй. Хэрэгжилт 0%

Тус байгууллагын 2024 оны дотоод аудитаар илэрсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийг харуулбал:

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт
1	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох шийдвэрийг мөрдөж ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах, удирдлагаас тавих хяналтыг сайжруулах.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн боловч биелэлтийг эхний хагас жилийн байдлаар ирүүлээгүй.
2	Албан томилолтыг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсний дараа тухай бүр мөнгөн урьдчилгааны тайланг гаргуулж хэвших.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн боловч биелэлтийг эхний хагас жилийн байдлаар ирүүлээгүй.
3	Шилэн дансны дутуу мэдээлсэн мэдээллүүдийг нөхөж оруулах.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн боловч биелэлтийг эхний хагас жилийн байдлаар ирүүлээгүй.

1.3 ӨМНӨ ХИЙГДСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус байгууллагын 2023 оны дотоод аудитаар илэрсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийг харуулбал:

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт
1	Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулах. Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө ажлын даалгавар, зураг төсөвтэй бараа, ажил, үйлчилгээг тусгах.	Аргачлал хяналтын зардал данснаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг ТБОНӨХББАҮХАТХуулийн босго үнийг баримтлан байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн тусгаагүй байна. Хэрэгжилт 50%
2	Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн босго үнийг баримтлан цахим дэлгүүрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх.	Үндэсний геологийн албаны худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнөөс харахад Урсгал зардал, Мэдээлэл технологи, Багаж хэрэгсэл, "Хээрийн шуурхай хяналтад шаардагдах хувцас /хавар, намар, өвөл/ бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг 2, 3 дугаар улиралд эхлүүлэхээр төлөвлөсөн байна. Цаашид төлөвлөлтийг 1 дүгээр улиралд багтааж төлөвлөхөөр зохион байгуулах шаардлагатай. Хэрэгжилт 70%
3	Геологийн судалгааны төслүүдийн барьцаа хөрөнгө, гүйцэтгэлийн баталгаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахад хүрэлцэхгүй байгааг анхаарч, журамд өөрчлөлт оруулах.	"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох" журмын төсөлд санал тусгаагүй. Хэрэгжилт 0%

Тус байгууллагын 2024 оны дотоод аудитаар илэрсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийг харуулбал:

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт
1	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох шийдвэрийг мөрдөж ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах, удирдлагаас тавих хяналтыг сайжруулах.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн боловч биелэлтийг эхний хагас жилийн байдлаар ирүүлээгүй.
2	Албан томилолтыг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсний дараа тухай бүр мөнгөн урьдчилгааны тайланг гаргуулж хэвших.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн боловч биелэлтийг эхний хагас жилийн байдлаар ирүүлээгүй.
3	Шилэн дансны дутуу мэдээлсэн мэдээллүүдийг нөхөж оруулах.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн боловч биелэлтийг эхний хагас жилийн байдлаар ирүүлээгүй.

4.3 ИЛЭРСЭН АСУУДЛУУД

2023 он:

Илэрсэн асуудал 1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
Бодит байдал: 2023 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж хоолны төлбөр, цайны зардалд 11,313,560 мянган төгрөгийг зарцуулсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур: Төсвийн тухай 16 дугаар зүйл 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад”.	
Асуудлын үндсэн шалтгаан: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төсвийг үр ашиггүй, дотоод хяналтгүй зарцуулах эрсдэл үүснэ.	
Зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох шийдвэрийг мөрдөж ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах.	

Илэрсэн асуудал 2	Аргачлал хяналтын зардал данснаас арга хэмжээг санхүүжүүлэхдээ худалдан авах ажиллагааны тухай хууль, журмыг мөрдөөгүй, шууд гэрээ байгуулжээ.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
Бодит байдал: Аргачлал хяналтын зардлаас албан томилолтын зардалд 2023 онд 64,179,400 төгрөгийг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсний дараа томилолтын гүйцэтгэл, мөнгөн урьдчилгааны тайлан, анхан шатны баримтын иж бүрдэл зэрэгт хяналт хэрэгжүүлээгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6 дугаар зүйлийн 2. “Мөнгөн урьдчилгааны тайлан НХМаягт ТМ-2 Мөнгөн урьдчилгааны тайлан нь гадаад, дотоод албан томилолт, хангамжийн урьдчилгаа гэх мэт бүх төрлийн мөнгөн урьдчилгааны гүйцэтгэлийг тайлагнах үндсэн баримт юм.Урьдчилгаа авагчийн гаргасан гүйцэтгэл ба олгосон урьдчилгаа, холбогдох анхан шатны баримттай нь харьцуулан нягтлан бодогч урьдчилгаа тайланг хянах ба илүү, дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт тус бүрээр гаргана.	
Асуудлын үндсэн шалтгаан: Хууль болон тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Бүртгэлээр тавих хяналт сулрах.	
Зөвлөмж: Албан томилолтыг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсний дараа тухай бүр мөнгөн урьдчилгааны тайланг гаргуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.	

Илэрсэн асуудал 3	Монголын Стратиграфийн комиссын ажиллах дүрмийн хэрэгжилт хангалтгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
Бодит байдал: Монголын Стратиграфийн комисс 2023 онд стратиграфийн чиглэлээр геологичдын хурал, зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж тухайн жилийн ажлын үр дүнг танилцуулаагүй, Үндэсний геологийн алба нь комиссын тайлан болон холбогдох шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагад жил бүр хүргүүлэх ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур: “Монголын Стратиграфийн комиссын ажиллах дүрэм”-ийн 4.5 “Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд стратиграфийн чиглэлээр геологичдын хурал, зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, дэмжих оролцох тухайн жилийн ажлын үр дүнг танилцуулж, шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлно ”, 5.6 “Комисс нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жилийн эцэст Үндэсний геологийн албанд, тус албан нь нэгдсэн тайлан, холбогдох шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хүргүүлнэ”	
Асуудлын үндсэн шалтгаан: Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Ажлын чанарт сөргөөр нөлөөлнө.	
Зөвлөмж: Монголын стратиграфийн комисс нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний Геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж мөрдөх, тайлагналтыг оновчтой тайлагнах, Үндэсний геологийн алба нь тайланг төрийн захиргааны төв байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлж байх.	

Илэрсэн асуудал 4	Редакцын зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилт хангалтгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
Бодит байдал: “Редакцын зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг батлуулаагүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур: Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/73 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Редакцын зөвлөлийн ажиллах журам”-ын 4.2 “Зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн саналыг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Үндэсний геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжүүлнэ”	
Асуудлын үндсэн шалтгаан: Журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Ажлын чанарт сөргөөр нөлөөлнө.	
Зөвлөмж: Редакцын зөвлөл нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний Геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж мөрдөх.	

2024 он:

Илэрсэн асуудал 5	Геологийн аргачлал хяналтын зардлын төлөвлөгөөнд бэлтгэл ажил хангагдаагүй ажлуудыг тусгаж байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
<p>Бодит байдал: Байгууллагын даргын 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан аргачлал хяналтын зардал данснаас санхүүжүүлэх ажил, үйлчилгээг төлөвлөхдөө ажлуудыг хэт задалж олон арга хэмжээг тусгасан, хэрэгжилт гарахгүй ажлуудыг төлөвлөсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тайлан мэдээ хүлээн авах, хяналт шалгалтын цахимжилт 19,500.0 мянган төгрөг; ❖ 1:25000-ны масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага хэвлэх 2,000.0 мянган төгрөг; ❖ 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчлол хэвлэх зардал 2,000.0 мянган төгрөгийг тус тус төлөвлөгөөнд тусгасан. ❖ Тайлбар бичгийн хадмал толь бичиг хийх ажлыг сэдвийн хүрээнд хэт задалж бичсэн 66,000.0 мянган төгрөг /төлөвлөгөөний 25-41 тусгагдсан/-ийн ажлуудыг хийхээр төлөвлөжээ. <p>1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчлол хийгдээгүй байхад хэвлэх зардал 2,000.0 мянган төгрөгийг төлөвлөгөөнд тусгасан.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Аргачлал хяналтын зардлыг төлөвлөхдөө батлагдсан ажлын даалгавар, зураг төсөв бараа, ажил, үйлчилгээг тусгах; ❖ Аргачлал хяналтын зардал данснаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг ТБОНӨХББАҮХАТХуулийн босго үнийг баримтлан байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, зориулалтын дагуу зарцуулна. 	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжихгүй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төсвийг үр ашиггүй, дотоод хяналтгүй зарцуулах эрсдэл үүснэ.</p>	
<p>Зөвлөмж: “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын дагуу шаардлагатай ажилд зарцуулах.</p>	

Илэрсэн асуудал 6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, үр ашиггүй худалдан авалтыг хийсэн.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
<p>Бодит байдал: ❖ Байгууллагын даргын 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан аргачлал хяналтын зардал данснаас санхүүжүүлэх 39,800.0 мянган төгрөгийн</p>	

<p>“Хээрийн шуурхай хяналтад шаардагдах хувцас /хавар, намар, өвөл/-г байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ТБОНӨХББАҮХАТХуулийн босго үнийг баримтлан харьцуулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн боловч сонгон шалгаруулалтыг зохион байгуулалгүй хуулиа зөрчиж шууд худалдан авалтыг хийжээ.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Өвлийн цагт хээрийн шуурхай хяналтыг зохион байгуулдаггүй бөгөөд шаардлагатай тохиолдолд ховорхон явах боломжтой байтал өвлийн хувцас захиалан батлагдсан орон тоогоор хийлгэж үр ашиггүй зардал гаргасан. ❖ Ажлын хувцас нь үнийн хувьд зах зээлийн үнээс өндөр байна.
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4, 13 дугаар зүйл</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллагын дотоод хяналт, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй. Шаардлагатай арга хэмжээнд зарцуулах төсөв хөрөнгө хязгаарлалт үүсэх.</p>
<p>Зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ➢ “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын хэрэгжилтийг хангаж ажиллах; ➢ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 250, 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” болон бусад эрх зүйн актын хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

Илэрсэн асуудал 7	Аргачлал хяналтын зардлын данснаас шаардлагагүй худалдан авалтыг хийсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй.
<p>Бодит байдал: Аргачлал хяналтын зардал данснаас шаардлагагүй худалдан авалтыг хийж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулжээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Хээрийн шуурхай хяналт шалгалт хийх 14 албан хаагчдыг 1,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий дархлаа дэмжих витаминь багцад хамруулж нийт 14,000.0 мянган төгрөг, ❖ Хээрийн шуурхай хяналт шалгалт хийхэд ашиглагдах аяны үүргэвч, норхоос хамгаалсан хаалт зэрэг хамтдаа нэг бүрийн үнийг 500.0 мянган төгрөгөөр байгууллагын нийт орон тоогоор авч нийт 17,500.0 мянган төгрөг зарцуулсан байна. ❖ ШУТИС-ийн Эрдэс баялгийн музейн урсгал зардал 15,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн. ❖ Худалдаж авсан дархлаа дэмжих витаминь багцын нэг бүрийн үнэ 1,000.0 мянган төгрөг, аяны үүргэвч, норхоос хамгаалсан хаалтын багцын нэг бүрийн үнэ 500.0 мянган төгрөг байгаа нь зах зээлийн үнээс хэт өндөр байна. 	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Аргачлал хяналтын зардал данснаас “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын 3.2.18, 3.2.19 заалтад тусгагдсан дараах арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд:</p>	

- ❖ Шуурхай хяналт хийх, хээрийн материал хүлээн авах;
- ❖ Судалгааны ажлын явцад гарсан маргаантай асуудлуудыг шийдвэрлэх;
- ❖ Геологийн судалгааны ажлын арга аргачлал, заавар зөвлөмж, норм боловсруулах, хэвлэн нийтлэх;
- ❖ Хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- ❖ Хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж худалдан авах;
- ❖ Редакцын зөвлөл, Монголын стратиграфийн комисс, ЭБМЗ-ийн геологийн судалгааны ажил хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүд, шинжээчийн зардал;
- ❖ ГСА-ын гүйцэтгэлийг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах;
- ❖ Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, танхим, цахим болон хээрийн сургалт зохион байгуулах;
- ❖ Салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах;
- ❖ Мэргэжил арга зүйн зөвлөлдөх хурал зөвлөгөөнд оролцох.

Аргачлал хяналтын зардал данснаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг ТБОНӨХББАҮХАТХуулийн босго үнийг баримтлан байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, зориулалтын дагуу зарцуулна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын дотоод хяналт, хуулийн хэрэгжилт хангалтгүй, санхүүгийн сахилга бат хангалтгүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны төслүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлангийн чанарт нөлөөлөх, Шаардлагатай арга хэмжээнд зарцуулах төсөв хөрөнгө хязгаарлалт үүсэх.

Зөвлөмж:

- “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 250, 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” болон бусад эрх зүйн актын хүрээнд худалдан авалтыг зохион байгуулах.

4.4 НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ:

2023 оны байдлаар:

1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хангаж ажиллаагүй;
2. Албан томилолтын гүйцэтгэлд удирдлагаас тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж хэвшээгүй;
3. Геологийн судалгааны аргачлал, хяналтын зардлын төлөвлөгөөг төлөвлөхдөө “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-нд заасны дагуу оновчтой төлөвлөх, хэрэгжүүлж болохуйц, үр дүнд суурилан боловсруулах шаардлагатай байна;

4. Монголын стратиграфийн комисс, Редакцын зөвлөл нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний Геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж мөрдөөгүй, тайлагналт хангалтгүй байна.

2024 оны байдлаар:

5. Төлөвлөлт оновчгүй, ойлгомжгүй олон арга хэмжээ (төлөвлөгөөний 25-41)-г тусгасан, бэлтгэл ажил хангагдаагүй хэрэгжихгүй төсөл арга хэмжээг тусгасан;
6. “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмыг зөрчиж зориулалт бусаар санхүүжүүлсэн;
7. Аргачлал хяналтын зардлын төлөвлөгөөнд тусгахдаа шууд худалдан авах босго үнэд нийцүүлэн бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийг жижгэрүүлсэн;
8. Шаардлагагүй худалдан авалтыг хийсэн;
9. Худалдан авалтыг хийхдээ хэрэгцээ шаардлагад нийцүүлэлгүй байгууллагын ажиллаж байсан орон тооноос хэтрүүлэн худалдан авалтыг хийсэн;
10. Аргачлал хяналтын зардал дансны зарцуулалтын тайлан гаргаагүй;
11. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, ажлын үр дүнг дээшлүүлэхэд анхаарахгүй байна.

ЗӨВЛӨМЖ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ:

1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох шийдвэрийг мөрдөж ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах;
2. Албан томилолтыг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсний дараа тухай бүр мөнгөн урьдчилгааны тайланг гаргуулж хэвших;
3. Журамд тусгасан зардлын ангиллын дагуу бодитой төлөвлөх, байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн тусгах;
4. Аргачлал хяналтын зардлаар геологийн төслүүдийн хэрэгжилт, үр дүнг сайжруулахад чиглэсэн, албан хаагчид, төсөл хэрэгжүүлэгчдийн сургах, норм стандартыг шинэчлэх, маргаантай асуудлыг шийдвэрлэх, тайлан хүлээн авах ажлыг цахимжуулах зэрэг өгөөжтэй ажлыг санхүүжүүлэх;
5. Аргачлал хяналтын зардлыг ангиллын дагуу гүйлгээг бүртгэх, зарцуулалтын тайлан гаргаж, удирдлагын зөвлөлийн хурлаар үр дүнг хэлэлцэж байх;
6. Удирдлагаас тавих дотоод хяналтыг сайжруулах, шаардлагатай бол дотоод хяналтыг нэгж байгуулж ажиллах;
7. Геологийн судалгааны тайланд шүүмж, шинжээчдийн цалин хэт бага байгааг судалж шийдвэрлэх, дагаад тавигдах шаардлага, хариуцлагыг нэмэгдүүлэх;
8. Төслүүдийн ажлын болон үр дүнгийн тайлангийн чанарт хяналт тавих мэргэжлийн хэлтсүүдийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх, бэлтгэхэд анхаарах;
9. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын 3.2.18, 3.2.19 дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлж хэвших;
10. Монголын стратиграфийн комисс, Редакцын зөвлөл нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний Геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж хэвших, тухайн жилийн ажлын тайлан, үр дүнг хэлэлцэж хамтын ажиллагааг дүгнэх, цаг хугацаандаа хүргүүлдэг байх, ирэх жилийн төсөв, төлөвлөгөөг батлахад уг дүгнэлтийг үндэслэх;
11. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, ажлын үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.

ТАНИЛЦСАН:

АҮЭБСайд
ТНБД-ын албан үүргийг
Түр орлон гүйцэтгэгч

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХШУДАГ-ын дарга
ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ХШУДАГ-ын ахлах шинжээч

ХШУДАГ-ын ахлах шинжээч

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ХШУДАГ-ын мэргэжилтэн

ТАНИЛЦСАН:

Үндэсний геологийн албаны дарга

Г.Дамдинням

Б.Дашпүрэв

Ц.Өнөрнасан

И.Баттуяа

Д.Батнайрамдал

Б.Баттуул

Г.Батчимэг

Н.Мөнхбилэг



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Геологийн судалгааны ажлын 2023 оны
аргачлал, хяналтын төлөвлөгөө, төсөв
батлах тухай


Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмын 3 дугаар зүйлийн 3.14, 3.16 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын аргачлал, хяналтын зардлын 2023 оны нэгдсэн төсвийг 1 дүгээр, хээрийн шуурхай хяналт хийх, хээрийн материал хүлээн авах ажлын төлөвлөгөө, төсвийг 2 дугаар, Монголын Стратиграфийн комиссын 2023 оны үйл ажиллагаа, цалингийн төсвийг 3 дугаар, Редакцийн зөвлөлийн үйл ажиллагаа, цалингийн төсвийг 4 дүгээр, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны 2023 оны үйл ажиллагаа, цалингийн төсвийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Геологийн судалгааны ажлын 2023 оны аргачлал, хяналтын зардлыг Үндэсний геологийн албаны геологийн судалгааны ажлын аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлэхийг ахлах нягтлан /Э.Мягмарсайхан/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Шинэ-од/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Уянга* Б.УЯНГА



100409 076

А/08... дугаар/дүгээр/ тушаалын 1 дүгээр
хавсралт

Геологийн судалгааны аргачлал, хяналтын зардлын 2023 оны нэгдсэн төсөв

/төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө
Орлого		
1	Төвлөрүүлэлт	934,091,194
Нийт дүн		
Зарлага		
1	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээж авах үйл ажиллагааны зардал	201,148,000
2	Монголын стратиграфийн комиссын зардал	86,800,000
3	Редакцийн зөвлөлийн зардал	31,980,000
4	Геологийн судалгааны ажилд хяналт тавихад шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж	12,970,000
5	Эрүүл, аюулгүй ажиллагаа болон үйл ажиллагаа сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа	22,250,000
6	Үр дүнгийн тайланг онцсайн хамгаалсан гүйцэтгэгчид олгох зардал	15,000,000
7	Үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх	70,000,000
8	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн улсын төсвийн санхүүжилттэй судалгаа хэлэлцэх салбар зөвлөлийн зардал	58,000,000
9	Геологийн салбарын хууль, тогтоомжийн төслийг боловсруулан танилцуулах, санал авах хэлэлцүүлэг зохион байгуулах	8,000,000
10	Геологичдын мэргэжил дээшлүүлэх практик сургалт-Шинэ дэвшилтэт программ хангамж ашиглалт, зураглал, эрлийн дадлагажих сургалт	32,000,000
	Геологчдийн ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулах зардал	76,188,000
11	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрэхээр дээж, сорьц авах, лабораторийн шинжилгээ хийлгэх зардал	3,000,000
12	Тайлан мэдээ хүлээж авах үйл ажиллагаа болон хяналт шалгалтын цахимжилт	49,000,000
13	Гео экологийн заавар, зөвлөмж боловсруулах	45,000,000
14	1:25000-ны масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага боловсруулах зардал	45,000,000
15	1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчол зохиох	50,000,000
16	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн талаар орон нутагтай хамтран ажиллах зардал/маргаантай асуудлыг шийдвэрлэх г.м/	3,000,000
18	Монгол улсын геологийн салбарын улсын зөвлөгөөн зохион байгуулах зардал	30,000,000
19	1:25000-ны масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага хэвлэх	2,000,000
20	1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчлол хэвлэх зардал	2,000,000
21	Хяналтад шаардагдах архивын нэгж үүсгэхэд ашиглагдах тоног төхөөрөмж, шүүгээ тавиур, хангамж худалдан авах, засварлах зардал	29,000,000
22	Геологийн шинэлэг мэдээлэл бүхий товхимол бэлтгэх (улирал тутам), хэвлэх зардал	1,000,000
23	Геологи судалгааны төсөл хэрэгжүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн бусад зардал	15,885,370
24	Зүүн өмнөд Азийн гео-шинжлэх ухааны төрийн байгууллагуудын холбооны 2023 оны гишүүнчлэлийн хураамж	35,180,000
25	Магадлашгүй ажлын зардал	9,689,824
Нийт дүн		
		934,091,194



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Геологийн судалгааны ажлын 2024 оны
аргачлал, хяналтын төлөвлөгөө, төсөв
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмын 3 дугаар зүйлийн 3.14, 3.16 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын аргачлал, хяналтын зардлын 2024 оны нэгдсэн төсвийг 1 дүгээр, Хээрийн шуурхай хяналт хийх, хээрийн материал хүлээн авах ажлын төлөвлөгөө, төсвийг 2 дугаар, Монголын Стратиграфийн комиссын 2024 оны үйл ажиллагаа, цалингийн төсвийг 3 дугаар, Редакцын зөвлөлийн үйл ажиллагаа, цалингийн төсвийг 4 дүгээр, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны 2024 оны үйл ажиллагаа, цалингийн төсвийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Геологийн судалгааны ажлын 2024 оны аргачлал, хяналтын зардлыг Үндэсний геологийн албаны геологийн судалгааны ажлын аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлэхийг ахлах нягтлан /Э.Мягмарсайхан/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /С.Шинэ-од/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.МӨНХТӨР



182401 00062

Үндэсний геологийн албаны 2024 оны
 02 дугаар сарын 26-ны өдрийн
 А/07 дугаар тушаалын хавсралт 1

Геологийн судалгааны аргачлал, хяналтын зардлын 2024 оны нэгдсэн төсөв

/төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө
Орлого		
1	Төвлөрүүлэлт	1,149,052,645
Нийт дүн		1,149,052,645
Зарлага		
1	Шуурхай хяналт, хээрийн материал хүлээж авах үйл ажиллагааны зардал	103,781,900
2	Монголын стратиграфийн комиссын зардал	146,078,600
3	Редакцийн зөвлөлийн зардал	111,948,600
4	Хээрийн шуурхайн хяналтанд шаардагдах багаж хэрэгсэл	17,500,000
5	Хээрийн шуурхай хяналтанд шаардагдах хувцас /хавар намар/	19,800,000
6	Хээрийн шуурхай хяналтанд шаардагдах хувцас /өвөл/	19,800,000
7	Геологийн судалгааны тайланг архивлахад шаардагдах зардал	18,000,000
8	Эрүүл мэндийн шинжилгээ	14,000,000
9	Эм эмнэлгийн хэрэгсэл	14,681,900
10	Үр дүнгийн тайланг онцсайн хамгаалсан гүйцэтгэгчид олгох зардал	15,000,000
11	Үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх	180,293,464
12	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн улсын төсвийн санхүүжилттэй судалгаа хэлэлцэх салбар зөвлөлийн зардал	72,704,181
13	Геологийн салбарын хууль, тогтоомжийг олон улсад сурталчилах, олон улсын туршлага судлах зардал	40,000,000
14	Монгол Улсад Үндэсний геологийн алба үүсгэн байгуулагдсаны 85 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах зардал	30,000,000
15	Геологчдийн ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах зардал	76,188,000
16	Геологийн судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр дээж, сорьц авах, лабораторийн шинжилгээ хийлгэх зардал	5,000,000
17	Тайлан мэдээ хүлээж авах үйл ажиллагаа болон хяналт шалгалтын цахимжилт	19,500,000
18	Гео экологийн заавар, зөвлөмж боловсруулах	10,796,000
19	1:25000-ны масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага боловсруулах зардал	19,800,000
20	Шинжлэх ухаан, технологийн санд хадгалагдаж байгаа Байгалийн шинжлэх ухаан, технологийн судалгааны ажлын тайлангуудыг Геологийн баримтын төв архивт шилжүүлэн авахтай холбоотой зардал	19,500,000
21	ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн Эрдэс баялгийн музейн урсгал зардал	15,000,000
22	"Геологийн судлагаа-шинжилгээний төв" ТӨҮГ болон Үйлдвэрлэлийн геологиудыг дэмжсэн сургалтын зардал	19,000,000
23	1:25000-ны масштабын геологийн зураглал хийх заавар, түүнд тавигдах шаардлага хэвлэх	2,000,000
24	1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилтай холбоотой зардлын норм, нормчлол хэвлэх зардал	2,000,000
25	Геодинамик, хавтангийн тектоник, далайн геологи	18,900,000

26	Структур геологи, ерөнхий геологи	3,000,000
27	Магмын чулуулаг	5,000,000
28	Геохронологи, геоморфологи, неотектоник, дөрөвдөгчийн геологи	3,000,000
29	Геохими, петрологи, петрохими	2,000,000
30	Нүүрс, газрын тос, хий, хүлэр, шатдаг занар	5,000,000
31	Гидрогеологи, инженер геологи, геоэкологи	3,000,000
32	Геофизик	4,000,000
33	Ашигт малтмал, металлогени, эрэл хайгуул, арга аргачлал	1,000,000
34	Палеонтологи, палеозоологи	4,500,000
35	Минераген, минералогии, петрографи, лаборатори	3,000,000
36	Палеоботаник /дээд, доод ургамал/	3,000,000
37	Метаморфизм, литологи	3,000,000
38	Зураглал, эрэл	3,000,000
39	Өрөмдлөгийн салбарын нэр томьёо	2,000,000
40	Стратиграфи	2,000,000
41	Нэр томьёоны хэл зүйн хяналт	1,000,000
42	Геологи судалгааны төсөл хэрэгжүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн бусад зардал /эрх зүйн маргаантай асуудлыг шийдвэрлэх орон нутагтай хамтран ажиллах г.м/	15,000,000
43	Геологийн шинэлэг мэдээлэл бүхий товхимол бэлтгэх (улирал тутам), хэвлэх зардал	1,000,000
44	Хяналтад шаардагдах архивын нэгж үүсгэхэд ашиглагдах тоног төхөөрөмж, шүүгээ тавиур, хангамж худалдан авах, засварлах зардал	13,000,000
45	Бичиг хэрэг	6,400,000
46	Зүүн өмнөд Азийн гео-шинжлэх ухааны төрийн байгууллагуудын холбооны 2024 оны гишүүнчлэлийн хураамж	35,180,000
47	Магадлашгүй ажлын зардал	19,700,000
Нийт дүн		1,149,052,645



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37, 29 дүгээр хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18072

Утас: 7018 1208, 7018 1447, 7018 1206,

Цахим шуудан: info@ngs.gov.mn,

Цахим хуудас: www.ngs.gov.mn

1825. 11. 25 № 1/832

танай _____ -ны № _____ -т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН ЯАМАНД**

Тус албаны 2023-2024 оны геологийн судалгааны
"Аргачлал хяналтын зардал данс"-ны зарцуулалтын
гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн дагуу
зөрчил арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга
хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт  хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Н.МӨНХБИЛЭГ



182505

833

Үндэсний геологийн албаны 2025 оны
11 дүгээр сарын 21-ны өдрийн 1/832
дугаартай албан бичгийн хавсралт

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛАГИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

АУДИТ-ын нэр: Үндэсний геологийн албаны Геологийн судалгааны "Аргачлал хяналтын зардал данс"-ны зарцуулалтад хийсэн хяналт шалгалт;
Хамрах хугацаа: 2023-2024 он

№	Зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцагч нэгж	Хэрэгжүүлэх хугацаа
1	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох шийдвэрийг мөрдөж ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах;	Ахлах нягтлан бодогчийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллана;	ТЗУХ Ц.Эрдэнэ-Очир	2026 оны I улиралд
2	Албан томилолтыг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсний дараа тухай бүр мөнгөн урьдчилгааны тайланг гаргуулж хэвших;	Мөнгөн урьдчилгааны тайланг тухай бүр гаргаж хэвшинэ.	ТЗУХ Ц.Эрдэнэ-Очир	2026 оны I-II улиралд
3	Журамд тусгасан зардлын ангиллын дагуу бодитой төлөвлөх, байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн тусгах;	2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-д тусгасан зардлын ангиллын дагуу 2026 оны Аргачлал хяналтын зардлын төсөв, төлөвлөгөөнд санал боловсруулж тусгаж ажиллана;	ТЗУХ Ц.Эрдэнэ-Очир	2026 оны I-II улиралд
4	Аргачлал хяналтын зардлаар геологийн төслүүдийн хэрэгжилт, үр дүнг сайжруулахад чиглэсэн, албан хаагчид, төсөл хэрэгжүүлэгчдийн сургах, норм стандартыг шинэчлэх, маргаантай асуудлыг шийдвэрлэх, тайлан хүлээн	- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Геологи, хайгуулын судалгааны ажил"-ын 2025 оны тендерт "Тера бит нет" ХХК шалгарч "Мэдээллийн системийн программ хангамж-2025" ажлыг эхлүүлсэн. Цаашид	ТЗУХ Ц.Эрдэнэ-Очир Т.Шихихутаг	2026 оны I-II улиралд

	авах ажлыг цахимжуулах зэрэг өгөөжтэй ажлыг санхүүжүүлэх;	сар бүрийн ажлын гүйцэтгэлийг уг цахим системээр хүлээн авах ба 2026 оны аргачлал хяналтын зардлын төсөв, төлөвлөгөөнд тухайн программтай холбоотой лиценз сунгалт, хөгжүүлэлт зэрэг программ ашиглахтай холбоотой нэмэлт төлбөрүүдийг тусган ажиллана. - Геологи, хайгуулын судалгааны ажлын норм, стандартыг шинэчлэн батлуулахаар ШУТИС-ийн эрдэмтэн багш нар ажиллаж байгаа бөгөөд ҮГА нь шаардлагатай тоон мэдээллийг гаргаж өгсөн бөгөөд 2026 оны 02 дугаар улиралд багтаан стандартыг батлуулж үйл ажиллагаандаа ашиглана;		
5	Аргачлал хяналтын зардлыг ангиллын дагуу гүйлгээг бүртгэх, зарцуулалтын тайлан гаргаж, удирдлагын зөвлөлийн хурлаар үр дүнг хэлэлцэж байх;	Аргачлал хяналтын зардлын зарцуулалтын тайланг сар бүр нэгтэн гаргаж, удирдлагын зөвлөлийн хуралд 2025 оны V улиралд явцын талаар, 2026 оны I улиралд үр дүнг тус тус хэлэлцүүлнэ;	ТЗУХ Ц.Эрдэнэ-Очир	2025 оны V-улиралд 2026 оны I- улиралд
6	Удирдлагаас тавих дотоод хяналтыг сайжруулах, шаардлагатай бол дотоод хяналтыг нэгж байгуулж ажиллах;	Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоол, АҮЭБСайдын 2025 оны А/169 дугаар тушаалын хүрээнд Үндэсний геологийн албаны бүтэц, орон тоог шинэчлэх ажлыг зохион байгуулах;	ТЗУХ Ч.Наранцэцэг	2025 оны IV - 2026 оны I улирал
7	Геологийн судалгааны тайланд шүүмж, шинжээчдийн цалин хэт бага байгааг судалж шийдвэрлэх, дагаад тавигдах шаардлага, хариуцлагыг нэмэгдүүлэх;	ЭБМЗ-ийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж танилцуулна.	ГСХ Х.Ганхуяг	2026 оны I- улиралд
8	Төслүүдийн ажлын болон үр дүнгийн тайлангийн чанарт хяналт тавих, мэргэжлийн хэлтсүүдийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх, бэлтгэхэд анхаарах;	Мэргэжлийн болон захиргаа, үйлчилгээний хэлтсүүдийн хүний нөөц, орон тоог нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авах.	ТЗУХ Ч.Наранцэцэг	2026 он
9	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын 3.2.18, 3.2.19 дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлж хэвших;	Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, албан хаагчдыг сургалтад хамруулах ажлыг байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулах. Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.	ТЗУХ Ц.Эрдэнэ-Очир Ч.Наранцэцэг	2026 оны I улирал

10	Монголын стратиграфийн комисс, Редакцын зөвлөл нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний Геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж хэвших, тухайн жилийн ажлын тайлан, үр дүнг хэлэлцэж хамтын ажиллагааг дүгнэх, цаг хугацаандаа хүргүүлдэг байх, ирэх жилийн төсөв, төлөвлөгөөг батлахад уг дүгнэлтийг үндэслэх;	Монголын стратиграфийн комисс болон Редакцын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж, батлуулах; Монголын стратиграфийн комисс, Редакцын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж хамтын ажиллагааг дүгнэх;	ГМТ ГСХ	2025 оны V-улиралд 2026 оны I- улиралд
11	Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, ажлын үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;	Аудитаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар 2025 оны V улиралд явцын талаар, 2026 оны I улиралд үр дүнг тус тус хэлэлцүүлэх;	ТЗУХ Б.Батлхагва	2025 оны V-улиралд 2026 оны I- улиралд

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

--00000000--